



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
 ЗАХИРАМЖ**

2021 оны 10 сарын 13 өдөр

Дугаар 11/161

Шивээговь сум

**Сумын “Эрүүл мэндийн төвд шаардлагатай”  
 тоног төхөөрөмж худалдан авах” ажлын  
 гүйцэтгэлийг хүлээж авах комисс томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 271 дүгээр “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам батлах тухай” тогтоол, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.12 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2021 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хэрэгжих сумын “Эрүүл мэндийн төвд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах” УВЧ шарлагын аппарат, цусны анализатор хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга:

О.Болормаа (Хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Ц.Замбага (Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдаа авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд:

Б.Болортайван (Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

А.Даваасүрэн (Эрүүл мэндийн төвийн лаборант)

Д.Сувд-Эрдэнэ (2 дугаар багийн иргэн)

2. Эрүүл мэндийн төвд шаардлагатай тоног төхөөрөмж болох УВЧ шарлагын аппарат, цусны анализаторыг эмнэлгийн үндсэн хөрөнгөд бүртгэж, ашиглалт хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн дарга (Б.Болортайван)-д үүрэг болгосугай.

3. Гүйцэтгэлийн ажлыг захиалагчаас гаргасан ажлын даалгаврын дагуу шаардлага хангасан тоног төхөөрөмжийг хүлээн авч, акт үйлдэн холбогдох баримтыг хавсарган хүлээлцэхийг комиссын дарга (О.Болормаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ